

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан

Гурван Талт Зөвлөлийн МЭДЭЭЛЭЛ

**Өмнөговь аймаг
Ханбогд сум**

**Иргэдийн хөгжлийн
төв**

2015 оны 7-р сарын 1

Та бүхэнд Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөлийн анхны уулзалтын мэдээг хүргэж байна. Энэхүү зөвлөл нь Олон улсын санхүүгийн корпорацийн омбудсмэн (CAO) байгууллагын оролцоотойгоор талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно.

Энэ удаагийн уулзалт Гурван талт зөвлөл байгуулагдсанаас хойш хийгдэж буй анхны уулзалт бөгөөд 2015 оны 7-р сарын 1-ний өдөр Ханбогд сумын Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Уулзалтыг CAO-ын газрын зуучлагч чиглүүлж, Ханбогд сумын Засаг даргын орлогч Х.Отгонжаргал тэргүүтэй Ханбогд сумын захиргааны төлөөлөл, Малчдын төлөөлөл болон Оюу толгой компанийн төлөөллүүд оролцлоо.

Уулзалтаар Ханбогд сумын малчдаас гаргасан гомдлын дагуу хийсэн Хөндлөнгийн шинжээчдийн I шатны үнэлгээний зөвлөмж болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ, Олон талт мэргэжлийн шинжээчдийн багийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийн төсөл, түүний зохион байгуулалт, Зөвлөлийн үрсгал зардал, Зөвлөлийн нарийн бичгийг сонгох зэрэг гол асуудлыг хэлэлцлээ.

Уулзалтын үр дүнд Хөндлөнгийн шинжээчдийн I шатны үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, Хөндлөнгийн шинжээчдийн II үе шатны ажлыг Олон талт мэргэжлийн шинжээчдийн ажилтай нэгтгэн хэрэгжүүлэхээр тохиролцлоо. Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Оюу толгой компанийн төлөөллийг түр ажиллуулахаар шийдлээ.

Ханбогд сумын Малчдын төлөөлөгчид, Сумын удирдлага болон Оюу толгой компанийн хамтарсан

Гурван Талт Зөвлөл